Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 175 дугаар тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ыг баталсан байна.

Уг НБББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2019 оноос хойш холбогдох хууль, эрхийн актуудад өөрчлөлт орсон тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 446,402.9 мянган төгрөгөөр буюу 8.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,539.0	1,750.2	-788.8
Авлага	336,906.5	-	- 336,906.5
Бараа материал	217,062.4	494,694.0	277,631.6
Үндсэн хөрөнгө	4,831,599.9	4,445,260.7	- 386,339.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,388,107.8</b>	<b>4,941,704.9</b>	<b>- 446,402.9</b>
Өр төлбөр	544,225.6	366,589.6	- 177,636.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,843,882.2	4,575,115.3	- 268,766.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө</b>	<b>5,388,107.8</b>	<b>4,941,704.9</b>	<b>- 446,402.9</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,750.0 мянган төгрөг болж 788.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын данс оны эхэнд 336,906.5 мянган төгрөг байсан бол оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан нь ЭМДС-аас авах санхүүжилтийг бүрэн авч, өмнөх оны өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 494,694.0 мянган төгрөг болж 277,631.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,669,064.7 мянган төгрөгийн материал худалдан авч, ХӨСҮТ-өөс 6,683.0 мянган төгрөгийн, аймгийн ЭМГ-аас 149,209.5 мянган төгрөгийн, сумын ЗДТГ-аас 15,870.0 мянган төгрөгийн эм, 1 удаагийн хамгаалах хэрэгсэл, оношлуур үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 1,563,195.6 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 6,182,913.5 мянган төгрөг болж 228,183.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 38,075.3 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авч, ЭМЯ-аас 23,024.4 мянган төгрөгийн сэргээн засах эмчилгээний эмнэлгийн тоног төхөөрөмж, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас 39,050.0 мянган төгрөгийн чих хамар хоолойн дурангийн тоног төхөөрөмж, ЭМГ-аас 5,685.8 мянган төгрөгийн эх барихын тоног төхөөрөмж, Дизрет ОУБ-аас 38,232.5 мянган төгрөгийн нярайн шаралт хэмжигч аппарат, Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2-р төвд 99,899.3 мянган төгрөгийн дээврийн их засвар хийсэн зэрэг ажил гүйлгээг төлбөргүй хүлээн авч, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийтийн эзэмшлийн 52,613.4 мянган төгрөгийн 15 хөрөнгийг бүртгэлээс хасаж, 14 хөрөнгийг 36,829.7 мянган төгрөгөөр дахин үнэлж орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,575,115.3 мянган төгрөг болж 268,766.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-ийн санхүүжилтээс 6,391,823.7 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 39,434.0 мянган төгрөг, нийт 6,431,257.7 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 223,896.1 мянган төгрөгийн орлогыг бууруулан тооцож ЭМДС-аас олгох санхүүжилтийг 6,167,813.1 мянган төгрөгөөр, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 39,548.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 6,207,361.6 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 118,718.6 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 105,177.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд ЭМДС-ийн санхүүжилтийн орлого 33,325.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 123,277.9 мянган төгрөгөөр, нийт 156,602.9 мянган төгрөгийн орлого давж биелсэн зэргээс шалтгаалан орлогын эх үүсвэрийг 600,978.7 мянган төгрөгөөр /цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 358,721.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 52,886.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад дардлыг 189,371.3 мянган төгрөгөөр/ нэмж тодотгон нийт зардлыг 6,808,340.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,808,340.3 мянган төгрөгийн төсөв баталж, ЭМДС-аас 6,737,227.4 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 71,112.9 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр ЭМДС-аас 6,201,138.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 162,826.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,364,588.4 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь нийт зардлыг 443,751.9 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал/80101/	6,509,177.0	6,204,975.5	304,201.5	95.3
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж/80802/	4,020.0	3,010.0	1,010.0	74.88
3	ЭМДС-ийн нэмэлт орлого /83603/	295,143.3	156,602.9	138,540.4	53.0
	<b>Дүн</b>	<b>6,808,340.3</b>	<b>6,364,588.4</b>	<b>443,751.9</b>	<b>93.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн 100130420401 тоот дансанд орлого төвлөрөөгүй бөгөөд өмнөх оны дансны үлдэгдэл 165.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны дансанд төвлөрүүлж, тус дансыг хаасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн гэрээний үүргийг дүгнэлгүйгээр төлбөр тооцоог гүйцэтгэсэн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг арилгах тухай зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,249,835.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 72,498.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 50,748.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 2/4474 дугаар төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлж ажиллах “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичигт дурдсан ажлуудыг хэрэгжүүлэн дараах зардлыг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- *Байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг хэмнэх зорилгоор цахилгааны тоолуурыг шинэчилсэн, дулаанаар хангах өдрийн тоог бууруулсан,*
- *Албан томилолтын зардлыг хэмнэх зорилгоор эрүүл мэндийн ажилтнуудын сургалт, уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан,*

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нэгдсэн эмнэлгийн мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түргэвчилсэн тестийн орлогыг төрийн санд тушаалгүй, зарцуулалтын эрх үүсгэлгүй хөрөнгө худалдан авсан, төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулах, авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэр бүрэн хөтөлж, бүртгээгүй зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	33,527.2	2	33,527.2	100
Зөвлөмж	2	18,657.8	2	18,657.8	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>52,185.0</b>	<b>4</b>	<b>52,185.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тухайн төсвийн шууд захирагчийн шийдвэрээр бус дээд шатны төсвийн захирагчдын шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлуудыг тэдгээрийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Ковид-19 цар тахал өвчний цар хүрээ намжмал байдалд орсон атал эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хэргэлдэхүүний нөөц бүрдүүлэх гэх үндэслэлээр шат шатны төсвийн захирагчдаас давхардуулан ашиглалтгүй эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хэрэглэгдэхүүнийг жил бүр үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгснөөр эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн **345,085.8 мянган төгрөгийн** үлдэгдэлтэй тайлагнагдсаныг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнээс:

- Аймгийн ЭМГ-аас 85,500.0 мянган төгрөгийн тоцилизумаб 400мг-тай ковидын тариа, 25,476.3 мянган төгрөгийн ремдесивир 100мг ковидын тариа, 18,379.7 мянган төгрөгийн хамгаалалтын хувцас, 8,476.4 мянган төгрөгийн N95 маск, 5,376.8 мянган төгрөгийн тамифлю, 6,000.3 мянган төгрөгийн хамгаалалтын нүүрний хаалт, нүдний шил зэрэг нийт 149,209.5 мянган төгрөгийн эм, тариа, эмнэлгийн хэрэгслийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгсөн нь тайлант онд зарцуулагдалгүйгээр эмийн тайланд үлдэгдлээр тайлагнагдсан байна.
- ХӨСҮТ-өөс нийт 6,683.0 мянган төгрөгийн ковидын xpert ultra №50, жане аппаратны RIFN-50 нэг удаагийн оношлуурыг үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн нь эмийн тайланд үлдэгдлээр тайлагнагдсан байна.
- Мандал сумын ЗДТГ-аас 7,000.0 мянган төгрөгийн хамгаалалтын хувцас, 4,575.0 мянган төгрөгийн нэг удаагийн бээлий, 4,295.0 мянган төгрөгийн 1 удаагийн хамгаалах хэрэгсэл, улавч малгай зэргийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгсөн боловч ашиглагдаагүй, эмийн тайланд үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

2. Тайлант онд ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 2.4.2-т “төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуустал хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх” гэж заасныг мөрдлөг болгон ЭМДС-аас авах 12 дугаар сарын 11-ээс 31-ийг хүртэлх хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний авлага болох 367,434.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

3. ЭМС-ын 2022 оны А/380 дугаар тушаалаар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр зинэлгийн дарга Ё.Буяндэлгэрт 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,946.2 мянган төгрөг, ахлах нягтлан бодогч Б.Баярсайхан, тооцооны нягтлан бодогч Ш.Мөнхбат нарт 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 3,264.4 мянган төгрөг, эм зүйч Г.Оюунчимэг, Ж.Наадам нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,632.1 мянган төгрөг, нийт 7,779.8 мянган төгрөгийг улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитын явцад дараах 66,675.2 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Үр дүнгийн тайлангийн бичиг хэргийн зардлыг 4,121.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Хог хаягдлыг зайлуулах,хортон мэргэчдийг устгах, ариутгалын зардлыг 29,715.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Цалингийн зардлыг 2,188.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 30,649.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,

Аудитаар нийт 7,820.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,820.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 3,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

### **5.1 Албан шаардлага**

1. Тус эмнэлэг нь Азийн нахиа ХХК-тай 22,017.4 мянган төгрөгийн өртөг бүхий "тархины цахилгаан бичлэгийн КТ-3200 32 сувагт дижитал видео аппаратыг түрээслэх" гэрээг 5 жилийн хугацаатайгаар байгуулан тайлант онд үйлчилгээний орлогоос 20,403.5 мянган төгрөгийг төлсөн бөгөөд дутуу төлбөрийн 14,784.0 мянган төгрөгийн өр төлбөртэйгээр тооцоо нийлж, аппаратын өртгийг бүрэн барагдуулсан байна. Цаашид гэрээний дагуу 4 жил ажиллавал Азийн нахиа ХХК-д дунджаар 140,750.0 мянган төгрөг төлөх буюу төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахаар гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", " гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Азийн нахиа ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээг цуцалж, төсвийг үр ашигтай байхаар зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Холбогдох албан тушаалтны тушаал, шийдвэр зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлээгүй гэх үндэслэлээр 3 албан хаагчид нийт **4,820.7** мянган төгрөгийн цалин олгож, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гөргөх үндэслэл болно", 13.7 дахь " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Тус эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэвшилтэт техник технологи ашиглан үзүүлэх зорилгоор сумын Засаг дарга, нэгдсэн эмнэлэг, МД Медикал клиникийн хооронд байгуулсан "Компьютер томографын аппарат түрээслэн хамтран ажиллах" гэрээг үндэслэн иргэдэд үзүүлсэн өндөр өртөгтэй үйлчилгээний санхүүжилтийг олгохдоо сар бүр үр дүнг тооцож, дүгнэлт гаргалгүйгээр зөвхөн нэхэмжлэхийн баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гөргөх үндэслэл болно", 13.7 дахь " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно",

хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Энэхүү гэрээний хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг дараах журмаар удирдан явуулна. А болон Б талаас томилогдсон удирдлагын гишүүд **ажлын үр дүн**, хөрөнгө мөнгөний зарцуулалтыг сар бүрийн 20-ны дотор бичгээр тайлагнах үүрэгтэй ба хамтын ажиллагааны талаар **дүгнэлт гаргаж өгнө**” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Ажлын үр дүнг үнэлсэн дүгнэлтийг тооцсоны үндсэн дээр түрээсийн төлбөр тооцоог гүйцэтгэж байх.

**2.1 Илрүүлэлт:** Нэгдсэн эмнэлэг нь СЭАМСНЭ/202203001/ дугаартай хүнсний материал нийлүүлэх ажлыг гүйцэтгэх тендерт шалгарсан ЭДБЭСС ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан боловч худалдан авалтын явцад үнийн маргаан үүсэж Мандал сумын сум дундын шүүхийн шүүгчийн 2022 оны 12 сарын 20-ны 149/ШЗ2022/00554 дүгээр “Зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” шийдвэрийн дагуу 3,000.0 мянган төгрөгийг нэхэмжлэгч ЭДБЭСС ХХК-д олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “Үр ашигтай байх”, 4.1.9 “Хариуцлагатай байх”, 4.2.3-дахь “Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**2.1 Өгсөн зөвлөмж:** Төсвийг үр дүн, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийн арвилан хэмнэлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайлангийн бичиг хэргийн зардлыг илүү тайлагнасан,	1	4,121.9			1	4,121.9	1	4,121.9				
Хог хаягдлыг зайлуулах,хортон мөргөчдийг устгах, ариутгалын зардлыг илүү тайлагнасан,	1	29,715.7			1	29,715.7	1	29,715.7				
Цалингийн зардлыг дутуу тайлагнасан,	1	2,188.5			1	2,188.5	1	2,188.5				
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг дутуу тайлагнасан,	1	30,649.1			1	30,649.1	1	30,649.1				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>66,675.2</b>			<b>4</b>	<b>66,675.2</b>	<b>4</b>	<b>66,675.2</b>				

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>4,820.7</b>			<b>1</b>	<b>4,820.7</b>						

/мянган төгрөгөөр/

Үндэслэлгүй гэрээ байгуулсныг цуцлах	1													
Гэрээг дүгнэлгүйгээр санхүүжилт олгосон	1									1				
Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	1	3,000.0								1	3,000.0			
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>7,820.7</b>								<b>2</b>	<b>4,820.7</b>	<b>2</b>	<b>3,000.0</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж							
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж									
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн						
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил														
<b>Дүн</b>														
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил														
<b>Дүн</b>														
<b>Нийт дүн</b>														